



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/428

Номгон

Г Хуримын ордныг түшиглэсэн гэр бүлийн зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг дэмжихэд хөрөнгө зарцуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь, Баянхонгор аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2.8.2 дахь, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.8.6 дахь, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай” 12/54 дүгээр тогтоолын хавсралтын 1.7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуримын ордныг түшиглэсэн гэр бүлийн зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг дэмжиж шаардлагатай материал, тоног төхөөрөмжөөр ханган үйлчилгээ үзүүлэхэд таатай орчин бүрдүүлэн ажиллахыг зөвшөөрсүгэй.

3.Гэр бүлийн зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг дэмжихэд шаардагдах 50.000.000 (Тавин сая) төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

642311235